



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/376

Булган сум

┌ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад ┐
настнуудтай уулзах уулзалт, сургалт хэлэлцүүлэгт
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, 42.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Саадгүй орчин, хүртээмжтэй үйлчилгээний тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны санаачилгаар хэрэгжиж буй “Гэрээсээ гарцгаая” аяны уулзалт, сургалт, хэлэлцүүлгийг 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдөр үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

2. Уулзалт, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахад шаардагдах хөрөнгө болох 3,205,000 (гурван сая хоёр зуун таван мянга) төгрөгийг хавсралтаар баталж, Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

